

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	7
2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	7
3 Менежментийн захидал.....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	15
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БШСУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БОЛОВСРОЛЫН ЧАНАРЫН
ШИНЭЧЛЭЛ ТӨСЛИЙН
ТЕХНИКИЙН ТЭРГҮҮЛЭХ
ЗӨВЛӨХ Ц.ХАЛИУН ТАНАА

2020.03.13 № 06/830
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсролын чанарын шинэчлэл төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Боловсролын чанарын шинэчлэл төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Боловсролын чанарын шинэчлэл төслийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал


Батлагдсан төсвийг 250,413.6 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан зөрчил нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Боловсролын чанарын шинэчлэл төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төслийн зохицуулагч Ц.Халиун Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн төсвийг хэтрүүлэн зарцуулахгүй байх, шилэн дансны мэдээллийг хугацаанд нь тогтмол байршуулах зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Боловсролын чанарын шинэчлэл төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 20-ноос 2020 оны 02 дугаар сарын 19-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар Нийслэл аудит ХХК-ын чанарын хяналтын менежер С.Сэрчхорол, аудитор Л.Ганзориг, Г.Жаргал аудиторын туслах Д.Ариунцэцэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

Боловсролын чанарын шинэчлэл төслийн удирдлага 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/05 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Олон Улсын Хөгжлийн Ассоциаци болон Монгол Улсын Засгийн Газрын хооронд 2015 оны 6 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан Санхүүжилтийн гэрээний дагуу 30 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр уг төслийг хэрэгжүүлэхээр болсон.

Төслийн зорилго нь бага боловсролын эх хэл, байгалийн ухаан ба математикийн сургалтын чанар, үр дүнг сайжруулж, сургуулийн түвшинд төлөвлөлтийг бэхжүүлэх замаар бага боловсролын чанарыг сайжруулахад оршино.

Энэ төсөл нь сургалтын үр өгөөжийг сайжруулах, багш бэлтгэх ба багшийн мэргэжил дээшлүүлэх, сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх, системийн удирдлага мониторинг гэсэн 4 бүрэлдэхүүн хэсэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус төслийн Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөж байгаа Дэлхийн банкнаас гаргасан төсөл хэрэгжүүлэх заавар нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Боловсролын чанарын шинэчлэл төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа "SQL server" программ хангамж ашигладаг байна.

Боловсролын чанарын шинэчлэл төслийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "Дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Боловсролын чанарын шинэчлэл төслийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөлтийн үе шатанд 8 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшнийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 13,451,450.0 мянган төгрөгөөс тооцон 134,514.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 1 хувь болох 134,514.5 мянган төгрөгөөр тооцсон нь Боловсролын чанарын шинэчлэл төслийн нийт орлого нь төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны цар хүрээг илтгэх тохиромжтой үзүүлэлт гэж үзэн материаллаг байдлын суурь болгон сонголоо.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Боловсролын чанарын шинэчлэл төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,452,992.0 мянган төгрөгөөр буюу 34 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,196,829.7	5,664,808.6	1,467,978.9
Авлага			
Урьдчилгаа	2,400.0	2,400.0	
Бараа материал			
Үндсэн хөрөнгө	78,799.5	63,812.6	(14,986.9)
Нийт хөрөнгө	4,278,029.2	5,731,021.2	1,452,992.0
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,278,029.2	5,731,021.2	1,452,992.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,278,029.2	5,731,021.2	1,452,992.0

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,467,978.9 мянган төгрөг буюу 35.0 хувиар өссөн нь олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрийн 2020 онд үргэлжлүүлэн хэрэгжих үйл ажиллагааны санхүүжилттэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 14,986.9 мянган төгрөг буюу 20.0 хувиар буурсан нь тайлант онд 20,986.7 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан нь голлон нөлөөлсөн байна. Тайлант онд 5,999.9 мянган төгрөгийн компьютер техник хэрэгсэл худалдан авсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5,731,021.2 мянган төгрөг болж 1,452,992.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Боловсролын чанарын шинэчлэл төсөл тайлант онд гүйцэтгэлээр 13,451,450.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 11,797,840.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 12,048,253.6 мянган төгрөг зарцуулсан нь 102.1 хувь байна.

Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд гадаад зөвлөх багш урьж ажиллуулсан нь төсвийн зардал 250,413.6 мянган төгрөгөөр буюу 2.1 хувиар хэтрэхэд нөлөөлсөн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 8 эрсдэл тодорхойлж, гүйцэтгэх үе шатанд 6 чиглэлээр 8 эрсдэлд нарийвчилсан горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 295,814.3 мянган төгрөгийн 3 алдаа, зөрчил илэрснээс, 45,400.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 250,413.6 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө. Үүнээс:

1. Санхүүгийн тайланд 40,400.7 мянган төгрөгийн үнэ бүхий компьютер, техник хэрэгслийг машин тоног төхөөрөмжөөр, 5,000.0 мянган төгрөгийн биет бүс хөрөнгийг бусад хөрөнгөөр тус тус бүртгэсэн байна.

Энэ нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, УСНББОУС-17 үндсэн хөрөнгө гэсэн стандартыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

Аудитаар илэрсэн 250,413.6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тайлант онд залруулсан үндсэн хөрөнгийн ангиллыг санхүүгийн программд залруулсан эсэхийг дараагийн аудитаар тодруулж үзэхээр шийдвэрлэв.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд нийт 112 мэдээллийг байршуулахаас 2 мэдээллийг цаг хугацаанд нь байршуулж, 7 мэдээллийг хугацаа хоцроож, үлдэх 103 мэдээллийг байршуулаагүй байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар жолоочийн замын хуудсыг бүрэн хөтөлж сарын эцэст бодит үлдэгдлийг тооцдог байх, хуулийн дагуу хувь хүнтэй гэрээ байгуулсан ажил гүйлгээ бүртээ холбогдох орлогын татварыг суутган авч төсөвт төвлөрүүлж байх 2 зөвлөмж өгсөн. 2019 оны жилийн эцсийн байдлаар өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг бүрэн биелүүлж хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Боловсролын чанарын шинэчлэл төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Аудитаар залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 134,514.5 мянган төгрөгөөс их байгаа тул “хязгаарлалттай” дүгнэлт өгч байна.

Боловсролын чанарын шинэчлэл төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөг эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: Тайлант хугацаанд батлагдсан төсвийн зардлыг 250,413.6 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдэлд нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл: Тайлант хугацаанд төслийн үргүй зардал гаргасан байх, холбогдох журам зааврыг хэрэгжүүлж ажиллаагүй байх;

3.1.3 Өгсөн зөвлөмж: Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах, хөрөнгийг үр дүнтэй удирдах, хяналт тавьж ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Боловсролын чанарын шинэчлэл төслийн 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/12 тоот албан бичгээр хариу тайлбар ирүүлсэн байна. Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

3.2. Шилэн дансны мэдээллийн талаа

3.2.1 Илрүүлэлт: Шилэн дансны мэдээлэлд 7 мэдээллийг хугацаа хоцроосон, 103 мэдээллийг оруулаагүй байна. Тухайлбал: Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг тухай бүр, батлагдсан төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэл, худалдан авалт, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт зэрэг мэдээллийг цахим хуудсанд хугацаанд нь байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3.1"Хуулийн хамрах хүрээ"3.1.5 "төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

- 3.2.2 Эрсдэл: Холбогдох хууль, журам, зааврыг хэрэгжүүлж ажиллаагүй байх, мэдээ, мэдээллийг нуун дарагдуулсан байх, тогтоосон хугацаанд цахим хуудсанд байршуулаагүй байх,
- 3.2.3 Өгсөн: зөвлөмж Боловсролын чанарын шинэчлэл төслийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд тогтмол мэдээлж байх Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл заалтуудыг хэрэгжүүлж ажиллах.
- 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	4,196,829,729.67	5,664,808,593.94
31100	Касад байгаа бэлэн мөнгө		
31200	Банкинд байгаа мөнгөн хөрөнгө	4,196,829,729.67	5,664,808,593.94
31210	Харилцах данс	313,462.65	1,000.00
31211	Төрийн сан	830,604.40	2,267,771,455.07
31212	Төрийн банк-гадаад валют	4,195,685,662.62	3,397,036,138.87
32100	УРЬДЧИЛГАА ТӨЛБӨР	2,400,000.00	2,400,000.00
32160	Урьдчилгаа тооцоо	2,400,000.00	2,400,000.00
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,199,229,729.67	5,667,208,593.94
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	78,799,442.76	62,979,302.20
39203	Авто тээврийн хэрэгсэл	80,200,000.00	80,200,000.00
39204	(Хуримтлагдсан элэгдэл)	(24,059,999.88)	(34,084,999.83)
39205	Компьютер техник хэрэгсэл	34,400,839.00	40,400,739.0
39206	(Хуримтлагдсан элэгдэл)	(19,074,984.34)	(27,845,191.45)
39207	Тавилга эд хогшил	7,532,000.00	7,532,000.00
39208	(Хуримтлагдсан элэгдэл)	(2,281,745.47)	(3,223,245.52)
39300	Биет бус хөрөнгө	2,083,333.45	833,333.50
39301	Программ хангамж	5,000,000.00	5,000,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,916,666.55)	(4,166,666.50)
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	78,799,442.76	63,812,635.70
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,278,029,172.43	5,731,021,229.64
51100	Засгийн газрын хувь оролцоо		
51200	Хуримтлагдсан үр дүн	4,278,029,172.43	5,731,021,229.64
51210	Өмнөх үеийн үр дүн	6,832,370,936.46	4,278,029,172.43
51220	Тайлант үеийн үр дүн	(2,554,367,622.35)	1,452,992,057.21
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ (ӨМЧИЙН ДҮН)	4,278,029,172.43	5,731,021,229.64
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ДҮН	4,278,029,172.43	5,731,021,229.64

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
120001	Гадаад зээлийн санхүүжилт	5,656,375,000.00	13,451,450,000.00
120002	Хүүгийн орлого	147,826,787.94	67,577,636.73
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	5,804,201,787.94	13,519,027,636.73
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		
210401	Цалин	220,563,337.37	
210402	Ажил олгогчоос НДШ	27,474,813.21	
210403	Бусад бараа үйлчилгээний зардал	71,133,517.48	56,593,572.37
210404	Бичиг хэргийн зардал	2,358,899.94	
210405	Тээвэр шатахууны зардал	6,871,018.18	1,840,000.00
210406	Шуудан холбооны зардал	4,743,707.84	2,199,847.31
210407	Ном хэвлэлийн зардал		1,000,700.00
210408	Жижиг эд хогшил худалдан авах зардал	4,422,300.00	104,500.00
210409	Банкны үйлчилгээний хураамж	214,123.60	
210410	Урсгал засварын зардал		1,661,818.00
210411	Байрны түрээсийн зардал	28,800,000.00	28,800,000.00
210412	Элэгдлийн зардал	16,653,367.92	20,986,707.06
210413	Аудит магадлалын хөлс	7,000,000.00	
210414	Тээврийн хэрэгслийн татвар	70,100.00	
210800	ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛ	8,596,681,540.89	12,006,646,822.09
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний хураамж	1,454,788,300.61	6,721,731,613.86
210900	Бараа үйлчилгээний бусад зардал	1,127,821,840.21	
210901	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	1,127,821,840.21	
22	Хөрөнгө шилжүүлсэн	6,014,071,400.07	5,284,915,208.23
220001	Тоног төхөөрөмж	6,014,071,400.07	270,026,455.0
221001	Бараа материал шилжүүлсэн		5,014,888,753.33
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	8,915,853,208.95	12,063,240,394.46
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	(3,111,651,421.01)	1,455,787,242.27
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	557,309,656.98	64,782,451.67
213300	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	557,309,656.98	64,782,451.67
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		67,577,636.73
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		67,577,636.73
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(2,554,341,764.03)	1,452,992,057.21

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
120001	Гадаад зээлийн санхүүжилт	5,656,375,000.00	13,451,450,000.00
120000	Бараа үйлчилгээний орлого		
120002	Хүүгийн орлого	147,826,787.94	67,577,636.73
134000	Тусламж санхүүжилтын орлого		
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	9,169,848.00	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	5,813,371,635.94	13,519,027,636.73
210401	Цалин	231,053,185.37	
210402	Ажил олгогчоос НДШ	26,154,813.21	
210403	Бусад бараа үйлчилгээний зардал	54,480,149.56	35,606,865.31
210404	Бичиг хэргийн зардал	2,358,899.94	
210405	Тээвэр шатахууны зардал	6,871,018.18	1,840,000.00
210406	Шуудан холбооны зардал	4,743,707.84	2,199,847.31
210407	Ном хэвлэлийн зардал		1,000,700.00
210408	Жижиг эд хогшил худалдан авах зардал	4,422,300.0	104,500.00
210409	Банкны үйлчилгээний хураамж	214,123.60	
210410	Урсгал засварын зардал		1,661,818.00
210411	Байрны түрээсийн зардал	28,800,000.00	28,800,000.00
210412	Аудит баталгаажуулалтын хөлс	7,000,000.00	
210413	Тээврийн хэрэгслийн татвар	70,100.00	
210800	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, хураамж	1,454,788,300.61	6,727,731,513.86
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	1,454,788,300.61	6,727,731,513.86
210900	Бараа ажил үйлчилгээний бусад зардал	1,127,821,840.21	
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлага	1,127,821,840.21	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЛАГЫН ДҮН	2,894,298,288.96	6,763,338,379.17
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	2,919,073,346.98	6,755,689,257.56
351000	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГО		
223000	Тонг төхөөрөмж		270,026,455.00
223010	Бусад хөрөнгө	6,014,071,400.07	5,014,888,753.23
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		67,577,636.73
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	6,014,071,400.07	5,352,492,844.96
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(6,014,071,400.07)	(5,352,492,844.96)
6	Санхүүгийн ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	557,309,656.98	64,782,451.67
7	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(2,537,688,396.11)	1,467,978,864.27
8	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	6,734,518,125.78	4,196,829,729.67
9	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,196,829,729.67	5,664,808,593.94

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2017 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл			6,832,370,936.46	6,832,370,936.46
C07	Тайлант үеийн үр дүн			(2,554,341,764.03)	(2,554,341,764.03)
D01	2018оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл			4,278,029,172.43	4,278,029,172.43
D08	Тайлант үеийн үр дүн			1,452,992,057.21	1,452,992,057.21
D09	2019 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл			5,731,021,229.64	5,731,021,229.64

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
12001	Татаас санхүүжилтийн орлого	13,451,450,000.00	13,451,450,000.00		100.0
12001	Бусад тусгай зориулалтын сангаас	13,451,450,000.00	13,451,450,000.00		100.0
12002	Бараа үйлчилгээний орлого		64,782,451.67		
12002	Төсөвт байгууллагын ажил үйлчилгээний орлого		64,782,451.67		
I	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	13,451,450,000.00	13,516,232,451.67	-64,782,451.67	100.5
II	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	11,797,840,000.00	12,048,253,587.40	-250,413,587.40	102.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,483,340,000.00	6,763,338,379.17	-279,998,379.17	104.3
210	Бараа үйлчилгээний зардал	103,450,000.00	35,606,865.00	67,843,135.00	34.4
210304	Байрны түрээс	28,800,000.00	28,800,000.00		100.0
210400	Хангамж бараа материалын зардал	11,000,000.00	5,145,047.31.00	5,854,952.69	46.7
210402	Тээвэр шатахуун	2,900,000.00	1,840,000.00	1,060,000.00	63.4
210403	Шуудан холбоо	2,400,000.00	2,199,847.31	200,152.69	91.7
210404	Ном хэвлэл	1,200,000.00	1,000,700.00	199,300.00	83.3
210405	Хог хаягдал хортон шавьж	2,000,000.00		2,000,000.00	
210406	БҮТЭЭ	2,500,000.00	104,500.00	2,395,500.00	4.2
210600	Эд хогшил, урсгал засвар	3,500,000.00	1,661,818.00	1,838,182.00	47.5
210601	Багаж техник	2,000,000.00		2,000,000.00	
210602	Тавилга	500,000.00		500,000.00	
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,661,818.00	-661,818.00	166.2
210700	Томилолтын зардал	60,150,000.00		60,150,000.00	
210701	Гадаад томилолт	50,000,000.00		50,000,000.00	
210702	Дотоод томилолт	10,000,000.00		10,000,000.00	
210703	Зочид төлөөлөгч	150,000.00		150,000.00	
210800	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хураамж	6,379,890,000.00	6,727,731,513.86	-347,841,513.86	105.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн үйлчилгээний төлбөр	6,379,890,000.00	6,727,731,513.86	-347,841,513.86	105.4
222000	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,314,500,000.00	5,284,915,208.23	29,584,791.77	99.4
222001	Тоног төхөөрөмж	900,000,000.00	270,026,455.00	629,973,545.00	30.0
222002	Бусад хөрөнгө	4,414,500,000.00	5,014,888,753.23	-600,388,753.23	113.6
IV	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		4,196,829,729.67		
V	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		5,664,808,593.94		

4.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөг)

Код	Үзүүлэлтүүд	төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		4,000,000,000.00
2100	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН		685,500,000.00
210300	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		7,200,000.00
210304	Байрны түрээс		7,200,000.00
210400	Хангамж, бараа материалын зардал		678,300,000.00
210402	Тээвэр, шатахуун		960,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		650,000.00
210404	Ном, хэвлэл		400,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр		676,290,000.00
222000	Хөрөнгийн зардал		3,314,500,000.00
222001	Бусад хөрөнгө		3,314,500,000.00

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020.02.20			САГ-2020/715/СТА-ТХН
Шалгагдсан байгууллагын нэр:	Боловсролын чанарын шинэчлэл төсөл		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант онд төсвийн зардал хэтэрсэн	250,413.6	зөвлөмж	Төслийн техникийн зөвлөх	Ц. Халиун
2	Шилэн дансны мэдээллийг цахимд бүрэн байршуулаагүй	-	Зөвлөмж	Төслийн техникийн зөвлөх	Ц. Халиун
Дүн		250,413.6			

